ИРВЭС ХАМГААЛАХ САН

# ЗУНЫ АЖЛЫН ДЭВТЭР

2020 он

# ГАРЧИГ


| | | |
|---|---|---|
| 1. | Оршил | 2 |
| 2. | Танилцуулга | 5 |
| 3. | Эх нутгаа танин мэдэхүй | 6 |
| 4. | Миний эргэн тойрны амьдрал | 7 |
| 5. | Одон орон судлал | 8 |
| 6. | Мал ямар ургамалд дуртай вэ? | 10 |
| 7. | Өдрийн тэмдэглэл | 11 |
| 8. | Улирлын өнгө | 12 |
| 9. | Сонсголонт байгаль | 13 |
| 10. | Үнэрт ертөнц | 14 |
| 11. | Байгалийн эд зүйлсээр урлагийн бүтээл урлахуй | 15 |
| 12. | Бидний хүрээлэн буй орчинд ургаж буй ургамал | 16 |
| 13. | Бидний мэдэж амжаагүй ургамалууд | 18 |
| 14. | Дасан зохицол | 19 |
| 15. | Аль нэг ургамал амьтдын байгаль дахь үүрэг ролийг тайлбарлан бичнэ үү? | 20 |
| 16. | Ирвэс ба түүний амьдрал | 21 |
| 17. | Цоохор ирвэсийг хэн сайн зурах вэ? | 22 |
| 18. | Хэрвээ би ургамал эсвэл амьтан байсан бол яах вэ? | 23 |
| 19. | Усны ухаалаг хэрэглээ | 24 |
| 20. | Үнэгүй юм гэж үгүй | 25 |
| 21. | Идэш тэжээлийн гинжин холбоо | 26 |
| 22. | Хог хаягдал юуг өгүүлнэ вэ? | 27 |
| 23. | Хэн байгаль орчин, ургамал амьтдын зургийг сайн авах вэ? | 28 |
| 24. | Орон нутагт тань байгаль орчны ямар асуудал байна? Яаж шийдвэл зохистойг ярилцаж бичнэ үү? | 30 |
| 25. | Байгаль орчин, ан амьтдын мэдлэгээ сайжруулах явцдаа Англи хэлнийхээ мэдлэгийг дээшлүүлээрэй. | 32 |

# ОРШИЛ

Хайрт хүүхдүүдээ,

Нэрт яруу найрагч Д.Нацагдорж “Миний нутаг” хэмээх алдарт зохиолдоо
“Хэнтий, Хангай,Саяны, өндөр сайхан нуруунууд
Хойд зүгийн чимэг болсон ой хөвч уулнууд
Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд
Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд
Энэ бол миний төрсөн нутаг
Монголын сайхан орон” хэмээн эх орныхоо үзэсгэлэнг уран зураг мэт сэтгэлд үлдэхээр дүрслэн шүлэглэсэн байдаг билээ. Үнэхээр их хувь заяагаар бид гайхамшигт Монгол орныхоо эзэд нь болсон аз завшаантай.

Хүүхдүүдээ, та нар гадаа гараад эргэн тойрноо нэг анхааралтай ажиглаад үзээрэй. Магадгүй байгаль дэлхий ямар олон өнгөтэйг, ямар содон дуу авиатайг, ямар өвөрмөц сонин болохыг чи анзаарч магад. Хүрээлэн буй орчинтойгоо танилцах тусам чамд улам ихийг мэдэх, эх орноо хайрлах сэтгэл төрөх буйзаа.

Эх орны минь ирээдүй хүүхэд та бүхний гарт бий. Эрдэм номтой, ажилч хичээнгүй хүмүүс болж эх орондоо газраа ухаж биш оюун ухаанаараа баялаг бүтээх эрин үе та бүхнийх байх болно гэдэгт итгэлтэй байна.

Зуны амралтаараа байгаль дэлхийтэйгээ бие даан танилцах чиний анхны аялалд хөтөч болгохоор Ирвэс Хамгаалах Сангийн ах эгч нар нь энэхүү ажлын дэвтрийг бэлтгэн та бүхэнд хүргэж байна. Энэхүү дэвтэр нь хүүхдүүд та бүхний танин мэдэх их хүсэл сонирхолд тань хөшүүрэг болно хэмээн найдаж байна.

Амралтын дараа аяны богц дүүрэн ирэхийг тэсэн ядан хүлээж байя.

Амжилт хүсье!!



Д.Нацагдорж ( Миний нутаг")

*Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд*
*Хотол олны эм болсон горхи, булаг рашаанууд*
*Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд*
*Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд*
*Энэ бол миний төрсөн нутаг*
*Монголын сайхан орон*
*Орхон, Сэлэнгэ, Хөхийн онц сайхан голууд*
*Уурхай баялагийн охь болсон олон уул давраанууд*
*Хуучин хөшөө дурсгал, хот балгадын суурингууд*
*Хол газар одсон харгүй дардан замууд*
*Энэ бол миний төрсөн нутаг*
*Монголын сайхан орон*
*Холхи газраас гялалзсан цаст өндөр хайрханууд*
*Хөх тэнгэр цэлмэсэн хөдөө хээр цайдамууд*
*Холын бараа харагдсан ноён шовх сарьдагууд*
*Хүний сэтгэл тэнийсэн уудам амьсгалт талууд*
*Энэ бол миний төрсөн нутаг*
*Монголын сайхан орон*
*Хангай говийн хооронд Халхын уудам нутаг*
*Хар бага наснаас хөндлөн гулд давхисан газар*
*Гөрөөс араатан авласан урт урт шилнvvd*
*Хүлэг морьд уралдсан хөндий сайхан хоолойнууд*
*Энэ бол миний төрсөн нутаг*
*Монголын сайхан орон*
*Салхины үзүүрт найгасан соргог нарийн ногоотой*
*Саруул талд ялралзсан сонин янзын зэрэглээтэй*
*Сайн эрс цугласан байц бэрх газартай*
*Сүлд тахилга улирсан сvмбэр их овоотой*
*Энэ бол миний төрсөн нутаг*
*Монголын сайхан орон*
*Нарийн өвс ургасан малын сайхан бэлчээртэй*
*Нааш цааш сүлжих тэнэгэр сайхан нутагтай*
*Дөрвөн цагийн улиралд дураараа нүүх нутагтай*
*Таван зүйлийн тарианы хөрс шороо газартай*
*Энэ бол миний төрсөн нутаг*
*Монголын сайхан орон*
*Өлгий сайхан ууланд өвгөдийг тавьсан газар*
*Үр, ач, хүүхдийн үржиж өссөн газар*
*Таван хошуу мал тал дүүрэн бэлчсэн нутаг*
*Монгол хvн бидний сэтгэлийг сорсон орон*

# ТАНИЛЦУУЛГА

Улс: ____________________

Аймаг: ____________________

Сум/Баг: ____________________

Сургууль: ____________________

Нэр: ____________________

Хобби: ____________________



# ЭХ НУТГАА ТАНИН МЭДЭХҮЙ

Амьдарч буй нутаг орныхоо уул, ус хаана ямар эрлэг амьтад байдаг тухай аав ээж, ах дүү нараасаа асууж тэмдэглэнэ үү



# МИНИЙ ЭРГЭН ТОЙРНЫ АМЬДРАЛ



Ажигласан амьтан ургамалаа зурж тэмдэглээрэй. Зурах явцад ажиглагдсан сонирхолтой зүйл таарвал бидэнтэй хуваалцаарай.



# ОДОН ОРОН СУДЛАЛ



Од эрхэсийг ажиглаж байх зуур ямар нэгэн дүрс олж харж байна уу?
Од хооронд зураас татаж, байж болох дүрсийг бүтээгээрэй.

# ОДОН ОРОН СУДЛАЛ



# МАЛ ЯМАР УРГАМАЛД ДУРТАЙ ВЭ?

Зун аав ээж, эмээ өвөөдөө туслан мал маллдаг бол энэ дасгал чамд хамгийн амархан бөгөөд сонирхолтой байх болно.
Дасгал ажил: Бэлчээрт буй малаа ажиглан ямар төрлийн ногоог ямар мал идэж байгааг тэмдэглэн аваарай. Ургамалын нэрийг сайн мэдэхгүй бол аав ээж, ах эгч нараасаа асуугаарай.



# ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ

Энэ хэсэгт тухайн өдөр ямар үйл явдал болсон, сонирхолтой хачирхалтай байгалийн үзэгдэл, ан амьтан ургамал харсан бол бидэнтэй сэтгэгдэлээ хуваалцаарай.

# УЛИРЛЫН ӨНГӨ

Байгаль дэлхий цаг үргэлжид өөрчлөгдөж байдаг бөгөөд тэрхүү хувьсал өөрчлөлтөө бидэнд тодорхой өнгө төрхөөр илэрхийлж байдаг. Хүрээлэн буй орчноо сайтар ажиглавал бид тэрхүү өөрчлөлтийн мөн чанарыг төвөггүй ойлгох болно.

**Дасгал ажил:** Нутаг орныхоо байгалийн гоо үзэсгэлэнт байдлыг дүрслэн зураарай.

# СОНСГОЛОНТ БАЙГАЛЬ



Чимээгүй байж биднийг хүрээлэн буй орчны чимээ анирыг анхааралтай сонсож байгаль дэлхийтэй улам ойр холбогдож түүнийхээ тухай захидал болон төрсөн сэтгэгдэлээ бичээрэй Дасгал ажил: Өглөө эртлэн босоод гадагш гаран чамд хэн ч саад болохгүй газар олоорой. Ингээд нүдээ аниад толгойгоо бага зэрэг тэнгэр өөд чиглүүлэн хоёр гарын алгыг дээш нь харуулах өвдөг дээрээ тавиад байгалийг дуу чимээг сонсоорой. Байгальтай ярилцсан сэтгэгдэлээ энд буулгаарай.



# ҮНЭРТ ЕРТӨНЦ



Байгалийн бүх л зүйл өөрийн гэсэн үнэр амттай байдаг. Энэ удаад бид өөр өөр үнэр бүхий ургамалыг үнэрлэх мэдрэхүйгээ ашиглан тайлбарлаж бичээрэй.

**Жишээ нь:** таана сонгино шиг үнэртэй байна гэх мэт

| No. | Ургамал (зураг) | Үнэр |
|---|---|---|
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |
| 5 | | |
| 6 | | |
| 7 | | |
| 8 | | |
| 9 | | |
| 10 | | |

# БАЙГАЛИЙН ЭД ЗҮЙЛСЭЭР УРЛАГИЙН БҮТЭЭЛ УРЛАХУЙ

Өөрийнхөө сэтгэмж дээр тулгуурлан чулуу, мод, навч, цэцэг байгалийн ямар нэгэн зүйл ашиглан урлагийн бүтээл урлан Цоохор ирвэсний тэмдэглэлт өдрийн уралдаанд оролцоорой.
Доорхи зайнд юу хийснээ бичих юмуу зургийг нь авч хавсаргаарай.



# Бидний хүрээлэн буй орчинд ургаж буй ургамал

Байгалийн ургамал амьтан бүр өөр өөрийн амьдрах нөхцөл орчинд шаарддаг билээ. Ингээд 5 төрлийн угамал сонгон авч ямар хөрсөнд болон орчинд ургаж байгааг тэмдэглэн бичээрэй. Ямар ургамал элсэрхэг газар, ямар ургамал хадархаг газар ургаж байна вэ? Яагаад гэсэн асуултыг өөрөөсөө болон гэр бүлийнхнээсээ асууж, хариулт олсон бол бидэнтэй доор хуваалцаарай.

| No. | Ургамал | Амьдрах орчин |
|---|---|---|
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |
| 5 | | |



# Бидний мэдэж амжаагүй ургамалууд

Байгаль дэлхий байнга өөрчлөгдөн хувирахын хирээр ургамалын төрөл зүйл ч бас өөрчлөгдөн хувьсаж байдаг. Тухайн нутаг оронд 20-30 жилийн өмнө бэлчээр ус ямар төлөвтэй байсан. Ихэвчлэн ямар ургамал ургадаг байсныг аав ээж, эмээ өвөөгөөс асууж одоогийн нөхцөл байдалтай харьцуулан бичээрэй.



# ДАСАН ЗОХИЦОЛ

Амьд биес тухайн орчиндоо дасан зохицох чадвартай байдаг билээ. Ингээд Говийн бүсийн ургамал амьтдын дасан зохицох зохилдолгоог 5 жишээ бичээрэй.

## Аль нэг ургамал амьтдын байгаль дахь үүрэг ролийг тайлбарлан бичнэ үү?

# Ирвэс ба түүний амьдрал

Байгалийн бусад зэрлэг ан амьтдын нэгэн адил цоохор ирвэсний амьдрал бэрхшээл аюулаар дүүрэн байдаг. Цоохор ирвэс бол нэн ховордсон, бидний тусламж хэрэгтэй байгаа амьтан юм. Цоохор ирвэсийг авран хамгаалах нь өндөр уулын экосистемийг бүхэлд нь хамгаалж улмаар бид өөрсдийнхөө нутаг орныг хамгаалж байна гэсэн үг юм.
**Дасгал ажил:** Орон нутагтаа цоохор ирвэсийг авран хамгаалах тулд ямар ажил санаачлан хийх хүсэлтэй байгаагаа бидэнтэй хуваалцаарай.



# Цоохор ирвэсийг хэн сайн зурах вэ?

# Хэрвээ би ургамал эсвэл амьтан байсан бол яах вэ?

Дасгал ажил: Өөрийгөө ямар нэгэн ургамал юмуу амьтанд орлуулан төсөөлөөд түүнд ямар бэрхшээл учирдаг талаар хүмүүст учирлан ойлгуулах захидал бичээрэй.



# Усны ухаалаг хэрэглээ



Дэлхий дээрхи бүх амьд зүйлсд ус хамгийн чухал. Бид усаа хаанаас авдаг, цэвэр сайн эсэхийг мэдэх нь мөн адил чухал юм.Ялангуяа говь нутгийн иргэд чандмань болсон усаа хайрлан гамнах хэрэгтэй. Говьд ихэнх ундны усны хэрэгцээ газрын дорхи гүний усаар худаг хангагдаж байдаг ба түүний нөөц нь шавхагдах аюултай юм.
Дасгал ажил: Танай гэрт өдөрт болон долоо хоногт хэдэн литр ус хэрэглэж байгаагаа тооцож үзээрэй. Эхлээд усны савны хэрэглээгээ тооцож ам бүлдээ хуваана. Ингээд танай гэрийн нэг хүн нэг өдөр юмуу, долоо хоногт хэдэн литр ус хэрэглэж байгааг гаргаж болно.
Цаашид сумын нийт ард иргэдийн тоонд үржүүлэн сумын хэмжээний хэрэглээг ч гаргаж болох юм.

# Үнэгүй юм гэж үгүй




Эргэн тойрны бүх эд юмс маань анхны эх үүсвэр байгалийн эд зүйлээс гаралтай байдаг. Бидний өдөр тутамд иддэг талх, боов гэхэд хөрснөөс үр тариа боловсорч түүнийг тээрэмдэн гурил гарган түүгээр нарийн боов хийдэг. Цаашлаад өмсөж буй даавуун хувцас гэхэд байгаль дахь хөвөн даавуунаас боловсруулан гаргадаг байна. Үүнийг хүний байгальд үлдээж буй экологийн ул мөр гэдэг. Хүүхдүүд та нар экологийн ул мөрөө багасгахын тулд дараах зүйлүүдийг хийх боломжтой.

- Хог хаягдлыг аль болох багасгаж боломжтойг нь эргүүлэн ашиглах
- Гадаадад үйлдвэрлэгдсэн хүнсний зүйл хэрэглэхийг аль болох багасагах
- Цөөн хувцасыг цэвэрхэн өмсөж, даавуун тор хэрэглэх
- Бүтээгдэхүүний сав боодлыг  эргүүлэн ашиглах
- Шаардлагагүй зүйлийг худалдан авахгүй зөвхөн нэн хэргэцээт зүйлсээ авах

**Дасгал ажил:** Эдгээр нэрлэсэн зүйлсээс аль алийг нь яаж хэрэгжүүлсэнээ бичээрэй.

# Идэш тэжээлийн гинжин холбоо

Манай дэлхий дээр амьдарч буй бүхий л амьд биетүүд хоорондоо нягт харилцан холбоотой байдаг билээ.

Мод ургамал гэхэд нарны гэрэл, хөрс бороогоор тэтгэгдэн өөрсддөө хоол тэжээл бий болгодог бүтээгчид юм. Харин амьтад бол ургамал ногоог хэрэглэж иддэг хэрэглэгчид юм. Ургамал амьтдад хэзээ нэгэн цагт үгүй болж байгальд шингэж задардаг байна.

Ирвэс гэхэд өвсөн тэжээлт амьтдын тоо толгойг байгальд зохицуулах үүрэгтэй ба өвсөн тэжээлт амьтад (гэрийн мал ч үүнд орно) хэт олширвол “бүтээгч” болох  ургамал бэлчээрийн эх үүсвэр муудна. Иймд ирвэс нь бэлчээрийн эрүүл мэндийг хангаж байдаг эмч байхнээ. Хэрэв аль нэгэн холбоос алга болвол (ургамал амьтдын нэг нь) байгальд ямар сөрөг нөлөөтэй болохыг бодолцоорой.

**Дасгал ажил:** Өөрийн ойлгож авсан байгальд дахь идэш тэжээлийн гинжин холбоог зурна уу.



# Хог хаягдал юуг өгүүлнэ вэ?

Дэлхий дахинд хуванцар хог хаягдалын асуудал байгаль орчинд заналхийлж байна. Иймд айл өрх бүр хуванцар хаягдалаа багасгахын төлөө чадах бүх арга хэмжээгээ авах хэрэгтэй. Жишээ нь чи дэлгүүрээс хуванцар савтай ундаа авахын оронд орон нутагтаа ургадаг жимс жимсгэнээр ундаа хийх ууж болно шүү дээ.

**Дасгал ажил 2:** Тохирох эд зүйлсийн нэрийг аль хог хаягдлын бүлэгт хамаарах байдлаар нь ангилж бичээрэй. Үүнээс өөр арван хог хаягдлын нэрийг олж бичээд доорх тохирох ангилалд байрлуулаарай:

Хөрсөнд шингэдэг



______________________________________

______________________________________

______________________________________

______________________________________

______________________________________

Шингэхдээ удаан



______________________________________

______________________________________

______________________________________

______________________________________

______________________________________

Задардаггүй үлддэг



______________________________________

______________________________________

______________________________________

______________________________________

Хорт хаягдал



______________________________________

______________________________________

______________________________________

______________________________________



# Хэн байгаль орчин, ургамал амьтдын зургийг сайн авах вэ?

Утас, камераа ашиглан авсан зургаа угаалгаад энд наагаарай



## Орон нутагт тань байгаль орчны ямар асуудал байна? Яаж шийдвэл зохистойг ярилцаж бичнэ үү?

Шинэлэг сонирхолтой төсөл Ирвэс Хамгаалах Сангийн санхүүжилт авч төслөө хэрэгжүүлэх боломтойг санаарай. Хүүхдүүд та нар төслөө бичихдээ эдгээр зүйлүүдийг харгалзаж үзээрэй.

Төслийн зорилго, төслийн зориулалт хэрэгцээ, оролцогчид, төсөлд шаардагдах хөрөнгө оруулалт. Үр дүнгийн тойм.Тухайн ажлыг хийснээр байгаль орчин, ан амьтан болон нутгийн иргэдэд ямар ач тус өгөх гэдгээ тусгаарай.



## Байгаль орчин, ан амьтдын мэдлэгээ сайжруулах явцдаа Англи хэлнийхээ мэдлэгийг дээшлүүлээрэй.

**Тохирох үгийг зурагтай холбоорой.**

**Gobi desert**



**Snow leopard**



**Ibex**



**Argali**



**Pika**



**Gazella**



**Mountain**



**Livestock**



**Plants**



**Grass**

